

“Тогтвортой хөгжил-Дээд боловсрол” Улсын II зөвөлгөөний “Сургалтын хөтөлбөрийн шинэчлэл” салбар хуралдаанаас гарсан зөвлөмжүүд

“Сургалтын хөтөлбөрийн шинэчлэл” салбар хуралдаанд 6 илтгэл хэлэлцүүлсэн бөгөөд илтгэлүүдийн агуулга, дэвшүүлсэн санал, дүгнэлтийг үндэслэн дараах зөвлөмжүүдийг нэгдсэн хуралдаанд танилцуулахаар төлөвлөж байна. Үүнд:

А. “Их дээд сургуулийн элсэлтийн шинэчилсэн бодлого”

Дэвшүүлсэн асуудал: Их, дээд сургуульд элсэгчдийн суурь мэдлэг, чадвар, хандлагын түвшин нь тухайн дээд боловсролын сургалтын байгууллагын сургалтын чанар, төгсөгчдийн чадамжид нөлөөлөх гол хүчин зүйлүүдийн нэг болно.

Санал, зөвлөмж:

1. Элсэлтийн ерөнхий шалгалтыг шалгуулагчийн мэдлэг, чадвар, хандлагын түвшинг тодорхойлох чиглэлд боловсронгуй болгох, улмаар их дээд сургуулиудийн элсэлтийн босго оноог элсэгчийн чадамжтай уялдаатайгаар ялгавартай тогтоодог болгох;
2. Элсэлтийн нэгдсэн цахим системийг бий болгож элсэлтийн үйл ажиллагааг улс орон даяар нэгдсэн байдлаар зохион байгуулах ажлыг 2018 оноос эхлэн хэрэгжүүлэх;
3. Их, дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрийн ирээдүйн чиг хандлага, төгсөгчдийн ажлын байрны зах зээлийн эрэлт хэрэгцээг үндэслэн элсэлтийн хяналтын тоог БСШУСЯ-наас тогтоодог болох.

В. Дээд боловсролын сургалтын хөтөлбөр-тогтвортой хөгжил

Дэвшүүлсэн асуудал: Сургалтын хөтөлбөрийг “Үр дүнд суурилсан боловсрол”-ын онол, арга зүйн дагуу боловсруулж, хэрэгжүүлж байгаа эсэхээс их, дээд сургуулиудын сургалтын чанар шууд хамаарна.

Санал, зөвлөмж:

1. Монгол хүний онцлог, бусад үндэстнээс ондооших давуу талууд, дэлхийн болон улс орны тогтвортой хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдаатай Монгол иргэн бүрийн зайлшгүй эзэмших нийтлэг мэдлэг, чадвар, хандлагыг тодорхойлж дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн суралцахуйн үр дүнд тусгах;
2. Ажил олгогчид, төгсөгчид зэрэг хөтөлбөр хэрэгжүүлэхэд оролцогч талуудаас судалгаа авах замаар хөтөлбөр, мэргэжлийн чиглэл бүрээр төгсөгчдийн эзэмшсэн байвал зохих тусгайлсан мэдлэг, чадвар, хандлагыг тодорхойлж хөтөлбөрийн суралцахуйн үр дүнд тусгах;
3. Дээд боловсролын сургалтын байгууллагуудын бүх шатны сургалтын хөтөлбөрт “үр дүнд суурилсан боловсролын хөтөлбөрт тавигдах шаардлага”-ын дагуу үнэлгээ, дүн шинжилгээ хийх, хэрхэн сайжруулах талаар арга зүйн зөвлөгөө өгөх, үе шаттай сургалтууд зохион байгуулах;
4. Сургалтын хөтөлбөрт төсөл, асуудал шийдвэрлэх даалгавар болон дадлага олгох хичээлүүдийг заавал тусгах, оюутнууд эдгээр хичээлээр дамжуулан бусад хичээлүүдээр эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагаа хэрэглээ болгох, улмаар бодит бүтээгдэхүүн, систем, үйл ажиллагаа, инноваци бий болгох боломжийг бүрдүүлэх.

С. Зайн сургалтын хөгжил ба насан туршийн боловсрол

Дэвшүүлсэн асуудал: Сургалтанд мэдээлэл, харилцаа холбооны технологи, суралцахуйн идэвхитэй арга зүй, хэлбэрүүдийг ашиглах замаар хөтөлбөрийн сургалтын үр дүнг дээшлүүлэх, боловсролын бодлогын суурь зарчим болох бүх иргэдэд тэгш хүртээмжтэй, чанартай сургалтын тогтолцоог бүрдүүлэхэд нийтийн, нээлттэй, насан туршийн онлайн сургалтын системийг өргөнөөр ашиглах.

Санал зөвлөмж:

1. Их дээд сургуульд зааж байгаа хичээлийн агуулгыг оюутнуудад нээлттэй болгох, онлайн болон танхимын сургалтыг зөв хослуулах арга зүйг боловсруулж түгээх, сургалтын орчинг бүрдүүлэх;
2. Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын мэдлэг, чадварыг жигдрүүлэх, оюутнууд хичээл судлах, төгсөгчдийг ахисан түвшний сургалтанд хамруулахад газар зүйн байршил, цаг хугацаанаас үл хамаарсан зайн сургалтын системийг ашиглах тогтолцоог бий болгох;
3. Орчин үеийн оюутан төвтэй сургалтын дэвшилтэт арга зүйг сургалтанд ашиглах санаачлагыг бодлогоор дэмжих, тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулах.

Д. Дээд боловсролын чанарын соёл

Дэвшүүлсэн асуудал: Их, дээд сургуулиудад чанарын дотоод баталгаажуулалтын тогтолцоог бүрэн хэрэгжүүлж, хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгийн гүйцэтгэлийн түвшинг тасралтгүй үнэлж, сайжруулах замаар чанарын соёлыг хэвшүүлэх .

Санал, зөвлөмж

1. Дээд боловсролын сургалтын байгууллагын бүтцэд чанарын дотоод баталгаажуулалт хариуцсан нэгж/алба/хэлтэс бий болгох асуудлыг бодлогоор дэмжих, түүний бүтэц, ажиллах хүрээг тодорхойлох, арга зүйгээр хангах;
2. Их, дээд сургуулиуд чанарын дотоод баталгаажуулалт хариуцсан мэргэжилтнүүдийг сонгон шалгаруулж, тэднийг чадавхижуулах сургалтыг үе шаттай зохион байгуулах;
3. Хөтөлбөр хариуцсан салбар, тэнхмүүд чанарын дотоод баталгаажуулалтын зорилгоор сургалтын хөтөлбөрт үнэлгээ хийх төлөвлөгөө боловсруулах, багш бүрийг хичээлийн суралцахуйн үр дүнг үнэлэх арга зүйд сургах зорилгоор үе шаттай сургалтууд зохион байгуулах;
4. Жил бүр чанарын дотоод баталгаажуулалтын тогтолцоог сайн хэрэгжүүлсэн сургуулиудыг шалгаруулж урамшуулах, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулах;
5. Сургалтын удирдлага мэдээллийн системийг чанарын дотоод баталгаажуулалтын гол хэрэглүүр болгон хөгжүүлэх арга зүйг боловсруулж их, дээд сургуулиудад түгээн дэлгэрүүлэх.

Е. Дээд боловсролын байгууллагын чанарын эрэмбэ тогтоох асуудалд

Дэвшүүлсэн асуудал: Дээд боловсролын сургалтын байгууллагуудын чанарын эрэмбийг тогтоосноор их, дээд сургуулиудын талаар хэрэглэгчдэд нээлттэй, бодит мэдээлэл өгөх, чанарын өрсөлдөөн бий болгох, улмаар олон улсын түвшинд эрэмбээ тогтоох, түүнийг дээшлүүлэх зорилгоор урт хугацааны төлөвлөлт хийх, хэрэгжүүлэх боломж бүрдэнэ.

Санал зөвлөмж

1. Дээд боловсролын байгууллагын чанарын эрэмбэ тодорхойлох шалгуур үзүүлэлтүүд, арга зүйг тодорхойлж батлан, эрэмбэ тогтоох ажлыг хэрэгжүүлэх бодлого, хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх;
2. Чанарын эрэмбэ тодорхойлох шалгуур үзүүлэлтүүдийн дагуу их, дээд сургуулиудыг эрэмбэлэх, шилдэг сургууль, багш нарыг урамшуулах тогтолцоог бий болгох;
3. Олон улсын чанарын эрэмбэ тогтоох байгууллагуудаар их, дээд сургуулиудын олон улсын түвшний эрэмбийг тодорхойлох, эрэмбээ дээшлүүлэх зорилгоор сургууль бүр стратеги төлөвлөгөө боловсруулах ажлыг 2018 онд багтаан хэрэгжүүлэх.

Г. Төгсөгчдийн ажил эрхлэлт, хөдөлмөрийн зах зээл, эргэх холбоо

Дэвшүүлсэн асуудал: Их, дээд сургууль ба ажил олгогч, төгсөгчдийн хамтын ажиллагаа, эргэх холбоог шинэ шатанд гаргаж хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгийн ач холбогдол ба гүйцэтгэлийн түвшинг үнэлүүлэх замаар хөтөлбөрийн тасралтгүй сайжруулалтад татан оруулах, тэднийг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх тогтолцоог бүрдүүлэх, төгсөгчдийн холбоогоор дамжуулан төгсөгч сургуулийн хөгжлийн асуудалд хувь нэмэр оруулах боломжийг нээх

Санал зөвлөмж

1. 21 зууны ажлын байр болон шинэ, хуучин мэргэжлийн чиглэл, хандлагыг судлан ирээдүйд монголын хөдөлмөрийн зах зээлд шаардлагатай ажил, мэргэжлийн жагсаалт, мэргэжилтний хэрэгцээг тодорхойлох;
2. Ажил олгогч, төгсөгчдөөс хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгийн ач холбогдол, төгсөгчдийн чадамжийн түвшинг тогтоох санал асуулгыг тодорхой төлөвлөлтийн дагуу тогтмол авдаг, үр дүнг хөтөлбөрийн сайржуулалтад ашигладаг тогтолцоог бүх дээд боловсролын байгууллагуудад хэвшүүлэх;
3. Хөтөлбөр бүрт ажил олгогч төгсөгчдөөс бүрдсэн мэргэжлийн зөвлөл байгуулж, тэдэнд хөтөлбөрийн сургалтын чанар, үр дүнг жилд 1-оос доошгүй удаа тайлагнаж санал, зөвлөмж авдаг тогтолцоог бий болгох;
4. Байгууллагуудын албан тушаал, ажлын байранд тавигдах шаардлагыг ажил горилогчийн боловсролын зэрэг болон мэдлэг, чадвар хандлагатай уялдаатайгаар тодорхойлсон стандартыг боловсруулж мөрдүүлэх;
5. Төгсөгчид ахисан түвшний болон богино хугацааны сертификатын сургалтанд хамрагдан мэдлэг, мэргэжил тасралтгүй дээшлүүлэх тогтолцоог бүрдүүлж, хэрэгжүүлэх;
6. Их, дээд сургуулиудын төгсөгчдийн холбооны үйл ажиллагааг олон улсын жишгийн дагуу шинэчилж идэвхижүүлэх ажлыг зохион байгуулах, төгсөгч сургуулийн хөгжлийн асуудалд хувь нэмэрээ оруулах хүсэл, сонирхлыг бодлогоор дэмжих.